

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 07 дугаар сарын 08 ны өдөр

**АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ КОМПЬЮТЕР, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ, ТАВИЛГА ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

БАГЦ-2: ДОТООДЫН ҮЙЛДВЭРЭЭС АВАХ ТАВИЛГА /УЛСЫН ХЭМЖЭЭНД/

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолт нь ИНҮТ-ийн албан хэрэгцээнд шаардлагатай тавилга /цаашид "бараа" гэх/-ын тодорхойлолт болон тавигдах шаардлага, тоо хэмжээг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартанд нийцсэн шинэ байна.

2.1 Нийлүүлэгчид тавигдах шаардлага

- 2.1.1 Нийлүүлэгч нь стандарт, шаардлагыг хангасан өөрийн агуулахтай байна.
- 2.1.2 Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүссэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцана, зөрчлийг арилгана.
- 2.1.3 Олон улс, Монгол Улсын чанар стандартын шаардлагыг хангасан үйлдвэрлэгч, нийлүүлэгч болохыг нотлох баримт бичиг ирүүлнэ.

2.2 Бараанд тавигдах шаардлага

- 2.2.1 Чанар стандартын шаардлагыг хангасан өнгө үзэмж сайн, хүснэгтэд өгөгдсөн хэмжээ, загвараар болон түүнээс дээш үзүүлэлттэй байж болно.
- 2.2.2 Барааны өнгө, загварын талаар захиалагчтай тохиролцсоны үндсэн дээр нийлүүлнэ. Сонголтуудтай фото зураг, танилцуулга ирүүлнэ.
- 2.2.3 Нийлүүлэх барааны үзүүлэлт, зураг бүхий танилцуулга, угсралтын зааврыг монгол эсхүл англи хэл дээр ирүүлнэ.

3. БАРААНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ТОО ХЭМЖЭЭ

Д/Д	Барааны нэр, төрөл	Барааны үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1. Ширээ					
1.1	Ширээ, тумбочка	- тавцан болон хөл маш сайн чанарын шахмал модон хавтан байх	Ком	35	Ажилтны

		<ul style="list-style-type: none"> - эмжээр нь PVC эсвэл зориулалтын материалаар хийгдсэн байх - уг материал нь хуурахгүй, ус чийг нэвтрүүлэхгүй, халуун хүйтэнд тэсвэртэй - өнгө, загвар дагуу татдаг шуургуулгатай тумбочкатай - Ширээний хэмжээ: 120 x 60 x 75см 			
1.2	Ширээ (хурал уулзалт)	<ul style="list-style-type: none"> - тавцан болон хөл маш сайн чанарын шахмал модон хавтан байх - эмжээр нь PVC эсвэл зориулалтын материалаар хийгдсэн байх - уг материал нь хуурахгүй, ус чийг нэвтрүүлэхгүй, халуун хүйтэнд тэсвэртэй - хэмжээ: 240 x 120 x 75см 	Ш	2	Дарга менежерийн өрөөнд
2. Шүүгээ, шкаф					
2.1	Бичиг хэргийн шүүгээ	<ul style="list-style-type: none"> - тавцан болон хаалга нь сайн чанарын шахмал модон хавтан байх - эмжээр нь PVC эсвэл зориулалтын материалаар хийгдсэн байх - уг материал нь хуурахгүй, ус чийг нэвтрүүлэхгүй, халуун хүйтэнд тэсвэртэй - хоёр хавтаст хаалгатай, эсвэл гүйдэг хаалгатай, дотроо хөндлөн тасалгаа бүхий тавцантай, түгжээтэй, дээрээ гурван тавиуртай шилэн хаалгатай 	Ш	15	
3. Оффис тавилга					
3.1	Буйдан (арьсан)	<ul style="list-style-type: none"> - албан зориулалтын буйдан - цэвэр арьсан бүрээстэй - хэмжээ: өндөр 45см, 190 x 80см 	Ш	2	Дарга, менежерийн өрөөнд
3.2	Буйдан (даавуун)	<ul style="list-style-type: none"> - албан зориулалтын буйдан - даавуун бүрээстэй - хэмжээ: өндөр 45см, 190 x 80см 	Ш	5	Ээлжийн ажилчдын амралтын өрөөнд

4. БУСАД НӨХЦӨЛ

4.1 Монгол улсад мөрдөгддөг стандарт шаардлага хангаж, чанарын гологдолгүй байна.

5. ХҮЛЭЭН АВАХ

5.1 Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан барааг нийлүүлнэ.

5.2 Нийлүүлэгч тал барааг тээвэрлэх, зөөхдөө бүрэн бүтэн байдлыг хариуцаж, заасан байрлалд угсарч байрлуулж өгнө.

5.3 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

5.4 Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар ба түүнээс дээш байх.

5.5 Ачааг хүргэх цэг: ИНҮТ, ХУД, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар, Монгол Улс

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү,
эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга,
Үнэлгээний хорооны дарга:




Ч.Сэржмаа

Иргэний нисэхийн үндэсний төвийн
Мэдээллийн технологийн хэлтсийн
Программ хангамжийн ахлах инженер,
Үнэлгээний хорооны гишүүн:


Ц.Ган-Эрдэнэ

“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Ж.Бямбасүрэн

“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл”
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Ц.Дэрэндаш

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах
ажиллагааны тасгийн ахлах мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг:



Б.Мөнхбаатар